



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Их Богд байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/173/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: П.Амаржаргал Утас: 88106992 Цахим хаяг: amarjargalp@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	16
4.2 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail: bayankhongor@audit.gov.mn

2022.02.16 № 2109

Г ИХ БОГДЫН БАЙГАЛЫН
ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ
ДАРГА Б.БАТ-ӨЛЗИЙ ТАНАА

танай _____ -ны № _____ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Их Богд байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Их Богд байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\2022 он пармаа\гэрчилгээ\A4-toot.docx

0050?0197

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	362,406,825.00	442,006,490.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	26,966,225.00	43,893,412.00
120	Нийтлэг татварын бус орлого	26,966,225.00	43,893,412.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	26,966,225.00	43,893,412.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	804,200.00	925,340.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,892,092.00	00.00
120017	Үнэ төлбөргүй Үндсэн хөрөнгө	00.00	42,640,000.00
120018	Үнэ төлбөргүй Бараа материал	00.00	328,072.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	20,269,933.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	335,440,600.00	398,113,078.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	325,440,600.00	367,459,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	325,440,600.00	367,459,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,000,000.00	30,653,278.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	15,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	15,653,278.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	376,382,379.70	406,846,326.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	376,382,379.70	406,846,326.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	315,214,406.82	337,270,601.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,174,354.82	206,871,600.56
210101	Үндсэн цалин	203,174,354.82	155,721,826.56
210102	Нэмэгдэл	00.00	39,056,174.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	12,093,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,743,307.30	28,079,306.78
210201	Тэтгэврийн даатгал	24,743,307.30	25,805,147.78
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	165,606.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	132,485.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	12,695.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	1,963,373.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	562,000.00	330,000.00
210302	Түлш, халаалт	562,000.00	330,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,094,389.75	30,577,585.21
210401	Бичиг хэрэг	1,959,320.00	1,844,500.00
210402	Тээвэр, шатахуун	13,191,988.00	23,895,262.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,462,231.00	1,326,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	86,800.00	1,037,700.00
210408	Бараа материал акталсны зардал	18,394,050.75	2,473,522.61
2105	Нормативт зардал	00.00	226,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	226,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,589,904.00	1,778,700.00

**Их Богд байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210604	Урсгал засвар	3,589,904.00	1,778,700.00
2107	Томилолт, зочны зардал	2,273,000.00	3,423,000.00
210702	Дотоод албан томилолт	2,273,000.00	3,423,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,576,552.00	45,337,405.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,172,952.00	44,812,205.38
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	59,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	133,950.00	148,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	237,800.00	64,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,031,850.00	253,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,200,898.95	20,646,503.65
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,200,898.95	20,646,503.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,167,972.88	69,575,725.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	41,391,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	41,391,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	61,167,972.88	28,184,225.28
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	61,167,972.88	12,530,947.28
213304	Хөрөнгийн	00.00	15,653,278.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-13,975,554.70	35,160,163.14
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	1,224,904.68
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	1,224,904.68
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-1,224,904.68
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-13,975,554.70	33,935,258.46

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	342,136,892.00	399,038,418.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,696,292.00	925,340.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,696,292.00	925,340.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,696,292.00	925,340.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	804,200.00	925,340.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,892,092.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	335,440,600.00	398,113,078.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	325,440,600.00	367,459,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	325,440,600.00	367,459,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,000,000.00	30,653,278.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	15,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	15,653,278.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	342,136,892.00	396,553,418.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	342,136,892.00	396,553,418.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	280,968,919.12	326,977,692.72

**Их Богд байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	183,680,297.13	207,274,084.56
210101	Үндсэн цалин	143,527,887.73	155,850,658.56
210102	Нэмэгдэл	29,040,220.53	39,329,826.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,121,300.00	12,093,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	2,990,888.87	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,874,397.99	27,340,998.76
210201	Тэтгэврийн даатгал	13,762,080.38	19,039,051.55
210202	Тэтгэмжийн даатгал	2,080,673.97	2,134,712.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,663,987.41	1,666,606.81
210204	Ажилгүйдлийн даатгал	396,139.92	385,878.65
210205	Эрүүл мэндийн даатгал	3,971,516.31	4,114,748.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	562,000.00	330,000.00
210302	Түлш, халаалт	562,000.00	330,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,253,281.00	15,885,200.00
210401	Бичиг хэрэг	352,050.00	1,123,600.00
210402	Тээвэр, шатахуун	17,211,000.00	12,434,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,630,231.00	1,386,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	60,000.00	940,700.00
2105	Нормативт зардал	277,000.00	277,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	277,000.00	277,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	1,702,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	52,900.00
210604	Урсгал засвар	00.00	1,650,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,273,000.00	2,235,000.00
210702	Дотоод албан томилолт	2,273,000.00	2,235,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,720,473.00	71,669,309.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	52,098,723.00	71,043,109.40
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	59,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	133,950.00	148,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	237,800.00	64,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	354,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	328,470.00	263,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	328,470.00	263,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,167,972.88	69,575,725.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	41,391,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	41,391,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	61,167,972.88	28,184,225.28
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	61,167,972.88	12,530,947.28
213304	Хөрөнгийн	00.00	15,653,278.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	2,485,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	2,485,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	2,485,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	2,485,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	2,485,000.00

Их Богд байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-2,485,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	36,953,494.00	1,120,118.12	48,137,560.65	86,211,172.77
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	36,953,494.00	1,120,118.12	48,137,560.65	86,211,172.77
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	17,229,463.91	17,229,463.91
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	36,953,494.00	1,120,118.12	51,391,469.86	89,465,081.98
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	36,953,494.00	1,120,118.12	51,391,469.86	89,465,081.98
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	36,953,494.00	1,120,118.12	51,391,469.86	89,465,081.98
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	33,935,258.46	33,935,258.46
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	36,953,494.00	1,120,118.12	85,326,728.32	123,400,340.44

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	368,459,800.00	355,854,192.72	12,605,607.28	96.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	368,459,800.00	355,854,192.72	12,605,607.28	96.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	326,016,000.00	314,462,692.72	11,553,307.28	96.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	214,442,600.00	207,274,084.56	7,168,515.44	96.66
210101	Үндсэн цалин	155,279,500.00	155,850,658.56	-571,158.56	100.37
210102	Нэмэгдэл	52,645,400.00	39,329,826.00	13,315,574.00	74.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,517,700.00	12,093,600.00	-5,575,900.00	185.55
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,949,700.00	27,340,998.76	1,608,701.24	94.44
210201	Тэтгэврийн даатгал	20,372,000.00	19,039,051.55	1,332,948.45	93.46
210202	Тэтгэмжийн даатгал	2,144,400.00	2,134,712.97	9,687.03	99.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,715,500.00	1,666,606.81	48,893.19	97.15
210204	Ажилгүйдлийн даатгал	428,900.00	385,878.65	43,021.35	89.97
210205	Эрүүл мэндийн даатгал	4,288,900.00	4,114,748.78	174,151.22	95.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,436,700.00	330,000.00	1,106,700.00	22.97
210301	Гэрэл, цахилгаан	240,300.00	00.00	240,300.00	0.00

**Их Богд байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210302	Түлш, халаалт	1,196,400.00	330,000.00	866,400.00	27.58
2104	Хангамж, бараа материалын зардал	15,885,200.00	15,885,200.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	1,123,600.00	1,123,600.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	12,434,900.00	12,434,900.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,386,000.00	1,386,000.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	940,700.00	940,700.00	0.00	100.00
2105	Нормативт зардал	277,200.00	277,200.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	277,200.00	277,200.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,187,900.00	4,187,900.00	0.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,537,900.00	2,537,900.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	1,650,000.00	1,650,000.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	2,251,700.00	2,235,000.00	16,700.00	99.26
210702	Дотоод албан томилолт	2,251,700.00	2,235,000.00	16,700.00	99.26
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	58,321,600.00	56,669,309.40	1,652,290.60	97.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	57,684,400.00	56,043,109.40	1,641,290.60	97.15
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	59,400.00	59,400.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	148,500.00	148,500.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	64,300.00	64,300.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	365,000.00	354,000.00	11,000.00	96.99
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	263,400.00	263,000.00	400.00	99.85
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	263,400.00	263,000.00	400.00	99.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,443,800.00	41,391,500.00	1,052,300.00	97.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,443,800.00	41,391,500.00	1,052,300.00	97.52
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,443,800.00	41,391,500.00	1,052,300.00	97.52
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	368,459,800.00	355,854,192.72	12,605,607.28	96.58
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	368,459,800.00	314,462,692.72	53,997,107.28	85.35
131001	Улсын төсвөөс санхүүжих	367,459,800.00	313,537,352.72	53,922,447.28	85.33
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	925,340.00	74,660.00	92.53
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	925,340.00	74,660.00	92.53
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	23.00	23.00	00.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620004	Гэрээт ажилтан	04.00	04.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,892,092.00	30,653,278.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,892,092.00	30,653,278.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,892,092.00	15,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,892,092.00	15,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,892,092.00	15,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,892,092.00	30,653,278.00
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	15,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,892,092.00	15,653,278.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Их Богд байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Их Богд байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлант хугацаанд хөрөнгө мөнгийг захиран зарцуулахдаа 2021.01.01-2021.03.25-ны хооронд Т.Ганболд, 2021.03.26-2021.12.31-ны хооронд Б.Бат-Өлзий нэгдүгээр гарын үсгийг, 2021.01.01-2021.08.31-ний хооронд С.Мөнхбаатар, 2021.09.01-2021.12-31-ний хооронд Т.Гантөмөр нар хоёрдугаар гарын үсгийг тус тус зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Их Богд байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Тусгай хамгаалалттай газар нутгийн экологийн тэнцвэрт байдал унаган төрхийг хадгалах зорилгоор судлан шинжлэх, хойд үедээ өвлүүлэх, байгаль орчныг хамгаалахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, байгалийн баялгийг зохистой ашиглахтай

холбогдсон хууль тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад стандартыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь БОАЖЯ-ны дотоод аудитын 2018.07.20-ны өдрийн 03-р тогтоолын заалт, зөвлөмжийг үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019.03.03-ны өдрийн А/58 тоот тушаалаар батлагдсан салбарын хэмжээнд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтад үндэслэн байгууллагын өөрийн онцлогт нийцүүлэн боловсруулж Их Богд байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын 2018.07.20-ны өдрийн А/43 тоот тушаалаар батлагдсан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

БОАЖЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Их Богд байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Их Богд байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 376,382.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,645.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,645.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 4,516.5 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Их Богд байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 33,935.2 мянган төгрөгөөр буюу 27.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	39,493.5	50,170.0	10,676.5
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	39,493.5	50,170.0	10,676.5
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	50,121.4	73,375.1	23,253.7
Үндсэн хөрөнгө	178,129.9	161,516.9	16,612.9
Хуримтлагдсан элэгдэл	(114,628.8)	(74,762.2)	(39,866.6)
Нийт хөрөнгө	89,615.1	123,545.1	33,930.1
Өр төлбөр	150.0	144.8	5.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	89,465.1	123,400.3	33,935.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	89,615.1	123,545.1	33,930.1

Бараа материалын дансны үлдэгдэл 50,170.0 мянган төгрөг болж 10,676.4 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал дансны үлдэгдэл өмнөх оноос 19,478.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба Дээд шатны төсөв захирагчаас тавьж олгосон санхүүжилтээр Баянлиг сумын нутагт Хөтлийн заг нэртэй газарт тарималжуулсан заг бүхий талбайд хамгаалалтын хайс, ус ажил хийгдэж түүний материалын орлого нь бараа материал голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 161,516.9 мянган төгрөг болж 16,612.9 мянган төгрөгөөр өссөн нь БОАЖЯ-ны сайдын 2021.09.20 А/283 тоот тушаал үнэ төлбөргүй шилжүүлэн ирсэн 42,640.0 мянган төгрөгийн УАЗ Фурган автомашиныг орлого авч, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021.12.02-ны өдрийн 589 тоот тогтоол, 2021.12.14-ний өдрийн 617 тоот тогтоолын дагуу тус тус 44,801.2 мянган төгрөгийн хөрөнгө, 18,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг акталж данснаас хассантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансанд тайлант онд төсвийн хөрөнгөөр 2,485.0 мянган төгрөгийн хөрөнгийн худалдан авч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271-р тогтоолын 4.1.1-д заасны дагуу холбогдох дансанд орлогоор бүртгэж бүртгэл тайланд тусгасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 123,400.3 мянган төгрөг болж 33,930.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 33,930.1 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 470,227.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 470,227.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 105,549.6 мянган төгрөгөөр бууруулж 364,678.1 мянган төгрөгөөр анх батлагдсан ба 2021 оны 10 дугаар сард төсөвт зохицуулалт хийгдэж 368,459.8 мянган төрөг болж 3,781.7 мянган төрөг буюу 1.0 хувиар өсөж батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 368,459.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 368,459.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 368,459.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 355,854.1 мянган төгрөгийг зарцуулж 12,530.9 мянган төгрөг буюу 3.5 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 355,854.1 мянган төгрөг буюу 96.5 хувьтай байгаа нь цалингийн зардал 7,168.5 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 1,608.7 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,106.7 мянга, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардал 1,052.3 мянга, хангамж бараа материалын зардлыг 1,594.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 15,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн Төрийн сан банкин дахь 100030013401 тоот дансаар олгосон бөгөөд БОАЖ-ын сайдын 2021.09.24-ны өдрийн А/296 тоот “Гэрээ байгуулах эрх олгох, хөрөнгө зарцуулах” тухай тушаалын дагуу Бөмбөгөр Хайрханы төгөл ХХК-тай 2021.10.08-ны өдрийн 2021 оны 01 тоот ажил гүйцэтгэх гэрээг байгуулан гэрээнд заасан хугацааны дагуу санхүүжилтийг 2021.10.21-ны өдрийн 34 тоот төлбөрийн хүсэлтээр 7,500.0 мянга, 201.11.24-ны өдрийн 54 тоот төлбөрийн хүсэлтээр 7,500.0 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус олгож 2021.11.08-ны өдрийн 2021/01 тоот ажил хүлээлцэх актаар гүйцэтгэсэн ажлыг хүлээн авсан байна.

Мөн нэмэлт санхүүжилтийн дансанд нөхөн төлбөрийн орлого болох 15,653.2 сая төгрөг төвлөрснийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь нөхөн төлбөрийн орлогыг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 54.10-т заасны дагуу “Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан Байгаль орчин, уур амьсгалын санд оруулна” гэж заасан нөхөн төлбөрийн орлогоор байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 15,653.2 мянган төгрөгийн орлого төвлөрснийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Мөн тус байгууллагад тайланд онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021.09.20-ны өдрийн А/283 тоот “Автомашин хуваарь батлах” тухай тушаалаар УАЗ Фургон 220695 маркийн 42,640.0 мянган төгрөгийн өртөг бүхий тээврийн хэрэгсэл ирснийг 2021.10.01-ны өдрийн 01 тоот Үндсэн хөрөнгө хүлээн авах, шилжүүлэх баримтаар хүлээн авч байгууллагын хөрөнгөд орлогоор бүртгэсэн байна.

Тайлант онд Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн Б/29 тоот тушаалаар нягтлан бодогч С.Мөнхбаатар, 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Б/16 тоот тушаалаар жолооч Ж.Баянжаргал нар өндөр настны тэтгэвэрт гарч байгаатай холбогдуулан албан ажлаас чөлөөлөгдөж хуулийн дагуу 41,391.5 мянган төгрөгийн тэтгэмжийг олгосон байна.

Дээрх албан тушаалын сул орон тоон дээр 2021 оны 09 дүгээр сарын 01-ны өдрийн Б/30 тоот тушаалаар Т.Гантөмөрийг нягтлан бодогчоор, 2021 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн Б/20 тоот тушаалаар Л.Зулбаатарыг жолоочоор тус тус томилсон байна.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 26 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 82.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 406,846.3 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 30,463.9 мянган төгрөгөөр буюу 7.5 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, эд хогшил худалдан авах зардал өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд нь өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь Шилэн дансны нэгдсэн системд нийт 151 мэдээлэл байршуулахаас 12 мэдээлэл хугацаа хоцроож 137 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	6	3	2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	3	1	
4	Сар бүр	3	36	28	8	
5	Тухай бүр	8	96	96		
	Нийт	27	151	137	12	2

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй бөгөөд урсгал төсвийн зарцуулалт нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолд нийцсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,171.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 6,727.4 мянган төгрөгийн зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дээд шатны төсөв захирагчаас тавьж олгосон санхүүжилтээр Баянлиг сумын нутагт Хөтлийн заг нэртэй газарт тарималжуулсан заг бүхий талбайд хамгаалалтын хашаа хийхэд хайс хийх тор 2,880.0 мянга, хашааны шон 1,650.0 мянга нийт 4,530.0 мянган төгрөгийн зардлыг зарцуулан байгууллагын бараа материалын дансанд орлогоор бүртгэж тухайн нутгийн харьяа байгууллагад хүлээлгэн өгөөгүй байгаа нь тус хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг хэрхэн хийж байгаа нь тодорхойгүй байгаа нь төсвийн үр ашгийг алдагдуулж байна. Цаашид энэ мэт зардлыг санхүүжүүлэн төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах байдлыг таслан зогсоох зайлшгүй шаардлагаар хамгаалалт хийх тохиолдолд чанартай насжилт өндөр материалаар хийж орон нутгийн үндсэн хөрөнгөнд бүртгүүлэн хүлээлгэн өгч төсвийн үр ашгийг дээшлүүлэх талаар анхаарч ажилласан эсэх талаар авч үзэх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 847.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 559.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 288.3 мянган төгрөгийн зөрчилд анхан шатны баримтыг үнэн зөв хөтлөх, хяналтыг сайжруулах, шилэн дансны цахим хуудаст байршуулах мэдээллийн хуулийн хугацаанд бүрэн, үнэн зөв мэдээлж байх 2 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Тайлант хугацаанд Баянговь сумын Байгаль хамгаалагч Ж.Батбаярт 07-р сарын цалингийн зөрүү 559.5 мянган төгрөгийг тооцож олгохдоо шууд зардлаар тайлагнасан байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар”-ын 5.3 дахь “Үр дүнгийн тайланг бэлтгэхдээ тухайн тайлангийн хугацаанд орлого, зарлагын ажил гүйлгээг аккруэл зарчмаар бүртгэнэ. Энэ зарчмаар орлогыг олсон бөгөөд хэмжих боломжтой болсон үед, зардлыг зардал гарсан бөгөөд хэмжих боломжтой болсон үед нь бүртгэдэг” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн шууд зардлаар тайлагнасан 559.5 мянган төгрөгийн залруулга хийв.

4.2 Зөвлөмж

1. Тус байгууллагын тайлант оны шатахууны зарцуулалтыг жолоочийн замын хуудастай тулгахад нярвын тайлангаас 288.3 мянган төгрөгөөр дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

2. Шилэн дансны нэгдсэн системд Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт мэдээг 1,8,9- сар, 3 дугаар улиралд, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт мэдээллийг 9-р сард, Дараа жилийн төсвийн төсөл мэдээллийг 1-р сард, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын, гүйцэтгэл мэдээллийг 1,8,9-р саруудад, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр мэдээллийг 9-р сард, Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт мэдээллийг 1, 9-р сар, Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 4-р сард байршуулахаас нийт 283,274.3 мянган төгрөгийн 12 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1. “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1. гэсэн хуулийн цаглаварт хугацаанд мэдээллийг бүрэн, хугацаанд нь үнэн зөв мэдээлж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Их Богд байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	3	847,8	1	559,5	0	0	0	0	2	288,3

_____оОо_____